



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/170

Улаанбаатар хот

Г Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсэг, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийг шүүх хуралдааны 2019 оны 11 дүгээр сарын 29-ний 615 дугаар тогтоол, Нийслэлийн Багануур дүүрэг дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2020 оны 02 дугаар сарын 17-ны 1/152 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүний их эмч Лхагвадоржийн Ихбаярт олгосон ИЭ0018069 сери, 0018069 дугаартай эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрөөс нэг жилийн хугацаагаар хүчингүй болгосугай.

2. Л.Ихбаярын эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай:

2.1 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаагаар хүчингүй болгосон тухай мэдээллийг эрүүл мэндийн ажилтны нэгдсэн санд бүртгэж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээлэх;

2.2 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүчингүйд тооцсон хугацаанд буюу 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдөр хүртэл мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад бүртгэж, оруулахгүй байх;

2.3 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүчингүй болгосон талаар тус яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо /Д.Цэрэндагва/, Ерөнхий мэс засал судлалын мэргэжлийн салбар зөвлөл /О.Ганбат/, Нийслэлийн эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/, Нийслэлийн Багануур дүүрэг дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс /Ц.Сандагдорж/-т албан бичгээр тус тус мэдэгдэх.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ

141200597